



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 181

Улаанбаатар хот

“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын
2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот
түвшин болон Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн
гэрээний биелэлтийн тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх журам”-ын 2.1, 3.1, 3.10, 4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон Захирал Б.Түмэн-Өлзийтэй байгуулсан 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг “Сайн” гэж дүгнэсүгэй.

2.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Захирал Б.Түмэн-Өлзийтэй Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн дарга (Ц.Баяр-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

3.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг ханган биелүүлж, 2024 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлт “Сайн” гэж дүгнэгдсэн Захирал (Б.Түмэн-Өлзий)-д хавсралтад заасны дагуу урамшуулал олгосугай.

4.Захирал Б.Түмэн-Өлзийд хавсралтын дагуу олгох урамшууллыг холбогдох эх үүсвэрээс гаргахыг “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч (Г.Төрбат)-д зөвшөөрсүгэй.

5.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132030633
9-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн
181 дүгээр тогтоолын хавсралт



“МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ
Б.ТҮМЭН-ӨЛЗИЙД 2024 ОНЫ АЖЛЫН ҮР ДҮНГЭЭР ОЛГОХ УРАМШУУЛАЛ

Д/Д	Хуулийн этгээдийн нэр	Захирлын нэр	Цэвэр ашиг (мян.төг)	Цэвэр ашгийн дүнгээс хасаж тооцох валютын ханшийн өөрчлөлтөөс олсон ашиг алдагдал (мян.төг)	Урамшуулал тооцох цэвэр ашиг (мян.төг)	Олгох урамшууллын хэмжээ (мян.төг)
1	“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газар	Б.Түмэн-Өлзий	53,480.600	0.0	53,480.600	6,069.612 (зургаан сая жаран есөн мянга зургаан зуун арван хоёр төгрөг)

.....000.....